шинэчлэн олгосон), 2004 оны 2 дугаар сарын 06-ны өдөр олгогдсон 6911А дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг шилжүүлэн авсан. Мөн 2017 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Ашигт малтмал газрын тосны газраас түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах нэрээр 020783 дугаартай, (137,77 Га талбайтай), 020784 дугаартай (435,22 Га талбайтай) ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг гаргуулан авсан.

2012-2013 онд “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК Халзан бүрэгтэй дэх MV-6911А, MV-12335А тусгай зөвшөөрлүүд бүхий талбайд өрөмдлөгийн үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд уг үйл ажиллагаа нь олон зөрчлийг агуулж байгаа талаар хэвлэл мэдээллээр мэдээлэл, нийтлэлүүд гарч, уг мэдээллийг тухайн үеийн аймгийн удирдлага анхааралдаа авч, улмаар хяналт шалгалт явуулахыг Мэргэжлийн хяналтын газарт даалгаснаар мэргэжлийн хяналтын улсын байцаагч шалгаад, “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК-ны Халзан бүрэгтэйд явуулж буй уг үйл ажиллагаа нь тухайн үеийн Ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.5, 25.1.6, 26 дугаар зүйлийн 26.2.3, 26.3.1, 26.7 дахь заалтуудыг тус тус зөрчиж олгогдсон, мөн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах хугацаандаа Ашигт малтмалын тухай хуулийн 6-р зүйлийн 35, 36, 37, 38, 39, 40, 41, 42, 43, 44 дүгээр зүйлүүдэд заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байсан учраас 2012 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 21-05/003/675 дугаартай “ашиглалтын лиценцийг цуцлуулах нь зүйтэй” гэсэн дүгнэлт гаргасан. Уг дүгнэлтийг үндэслэн тухайн үеийн Ховд аймгийн Засаг дарга Г.Нямдаваа хууль бус тусгай зөвшөөрлийг цуцлуулахыг хүсэж Ашигт малтмалын газарт 2012 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 1/774 дугаар албан бичгээр, АМГ-ын Геологи уул уурхайн кадастрын хэлтэст 2012 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 1/1297 дугаар албан бичгээр тус тус хандсан. АМГ-аас ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлахын тулд Байгаль орчны асуудал эрхлэсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт хэрэгтэй гэж хариу өгсөн тул баримт нотолгоог үндэслэн дүгнэлт гаргаж өгөхийг хүсэж тухайн үеийн Байгаль Орчин Ногоон Хөгжлийн Яаманд 2012 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 1/1415 дугаартай албан бичгээр мөн хандсан. Гэвч БОНХЯ-наас хариу ирүүлээгүй, дүгнэлт гаргаагүй бөгөөд уг асуудал орхигдсон байдаг.

**3.2.1.** Эдгээр зөрчлүүдээс гадна “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК-ний явуулж байсан үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчин, хүн ам, мал амьтны эрүүл мэндэд эрсдэл учирч байж болзошгүй нөхцөл байдал нүүрлэсэн зэргээс болж нутгийн ард иргэд, Мянгад сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, багуудын иргэдийн нийтийн хурал, нэр бүхий төрийн бус байгууллагууд, хөдөлгөөнүүд (“Алтай бидний шүтээн” “Ховдын толь сонин” НҮТББ, “Мянгад нутгийн төлөө хөдөлгөөн” НҮТББ) компаний үйл ажиллагааг эсэргүүцэж, Ховд аймгийн ИТХ түүнчлэн Монгол Улсын Их хуралд хүртэл хандасны улмаас 2013 оны 3 дугаар сард Ховд аймагт бүх талуудыг оролцуулсан хяналт шалгалт, нээлттэй хэлэлцүүлэг явагдаж, улмаар “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК үйл ажиллагаагаа зогсоосон.

2022 оныг хүртэл тус компани уг газарт дахиж очоогүй, үйл ажиллагаа явуулаагүй байж байгаад мөн оны 9 дүгээр сард гэнэт ирж, дахин өрөмдлөг хийж эхэлсэн. Урьд мэдэгдсэн ноцтой асуудлуудтай холбоотойгоор Мянгад сумын болон зэргэлдээх Буянт, Дөргөн, Чандмань зэрэг сумдын ард иргэд, мөн төрийн бус



байгууллагууд төрийн холбогдох байгууллагуудад гомдол санал хүргүүлж, асуудал тавьсны улмаас 2022 оны 11 дүгээр сард Монгол Улсын Засгийн газар, Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлөөс мэргэжлийн ажлын хэсэг томилсон. Томилогдсон ажлын хэсэг Ховд аймгийн Засаг Даргын Тамгын газар мөн санал асуудал тавьсан төрийн бус байгууллагууд, ард иргэдийн оролцоотойгоор хяналт шинжилгээ хийж, юуны өмнө тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбайн ойр орчимд болон талбайн хэсэгт цацраг идэвхт бодисын илрэцийг тодорхойлох хэмжилтийг Монгол улсын Цөмийн энергийн комисс болон Цөмийн энергийн газар, МУИС-ын Ховд аймаг дахь салбар сургууль, Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн ажлын алба, мөн компаний цацрагын шинжээчид, мэргэжилтнүүдээр өөр өөрсдийн хэмжилтийн баталгаажсан багажуудаар нь нэгэн зэрэг хэмжилт хийлгэснээс гадна тухайн газраас дээж авч Цөмийн Энергийн Газар, Мэргэжлийн хяналтын газруудын лабораторт шинжлүүлсэн. Мөн 2012 оноос хойш хийгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтүүдийг нягтлан шалгасан. Үүний үр дүнд тус ажлын хэсгийн тайланг үндэслэн, Цөмийн Энергийн Комисс, Үндэсний Аюулгүй Байдлын зөвлөлийн дүгнэлт гарсан. Тодруулбал Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 1/877 дугаар дүгнэлт зөвлөмжид Халзан бүрэгтэй дэх газрын ховор элементийн илрэл бүхий орд газар дахь “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК-ний тусгай зөвшөөрөл эзэмшиж, үйл ажиллагаа явуулж буй талбайд цацраг идэвхт изотопуудын илрэл, тунгийн хэмжээ нь Цөмийн энергийн тухай хууль болон мэргэжлийн стандартад заагдсан “чөлөөлөгдөх хэмжээ”-нээс даруй 30-аас дээш хувиар хэтэрсэн байдалтай байгаа тул цөмийн аюулаас хамгаалах стандарт болон дүрэм журмыг зайлшгүй мөрдөх шаардлагатай гэж дүгнэсэн байна. Тэрчлэн уг газар нь цөмийн энергийн тухай хуулийн 3.1.5, 3.1.15-д тус тус заасан цөмийн бодис, цөмийн эх үүсвэр материалыг агуулсан, цацраг идэвхт ашигт малтмал бүхий орд газар гэдэг нь уг дүгнэлтээр нотлогдсон.

**3.2.2. Цөмийн энергийн комиссоос 2023 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 1/24 дугаар албан тоотоор хүргүүлсэн дүгнэлт зөвлөмжид тухайн газарт олгогдсон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл нь 2009 оны 7 дугаар сарын 26-нд батлагдсан Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөлд тооцогдож, 2009 оны 11 дүгээр сарын 15-наас өмнө “уг хуульд заасан нөхцөл журмын дагуу” шинэчлэн бүртгэгдэх ёстой байсныг мэдэгдсэн байна. Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх тухай хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Цөмийн энергийн комисст өргөдлөө гаргаж, өөрийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүдээ шинэчлэн бүртгүүлэх ёстой байсан боловч энэхүү үүргээ хэрэгжүүлээгүй явж ирсэн. Түүгээр ч зогсохгүй дээрх тусгай зөвшөөрөл бүхий талбайнууд болон түүний орчмоос авсан дээжүүдийг лабораторт шинжилсэн 20-оод удаагийн шинжилгээний дүнгээр цацраг идэвхт бодис, изотопын илрэл нь тус бүрдээ зөвшөөрөгдөх буюу чөлөөлөгдөх хэмжээнээс даруй 30-аас дээш хувиар хэтэрсэн, цөмийн аюулаас хамгаалах арга хэмжээнүүдийг даруй хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байхаар илэрхийллийг үзүүлсэн байтал компани эдгээр шинжилгээний дүнгүүдийг зориуд нуун дарагдуулж, төр захиргааны холбогдох байгууллагууд, орон нутгийнханд илтээр худал мэдээлсээр ирсэн. Өдгөө ч Цөмийн энергийн комисс, Үндэсний аюулгүй байдлын дүгнэлтийг**

гуйвуулан, “чөлөөлөгдөх хэмжээнээс бага гэж гарсан” хэмээн санаатайгаар илт худал сурталчилгаа явуулсаар байна.

**3.2.3.** “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК энд дурьдаж буй хайгуулын лицензтэй газарт хийлгэсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээндээ ШУА-ийн судлаачдаар гаргуулсан археологийн судалгааны дүгнэлтийг шаардлагын дагуу хавсаргасан байсан бөгөөд уг дүгнэлтэнд тухайн газарт түүх соёлын үл хөдлөх дурсгал огт илрээгүй гэж тодорхойлсон байсан. Гэтэл Ховд аймгийн Соёлын өвийн судлаачид, НҮТББ-ууд хамтран 2022 онд уг газарт судалгаа хийхэд 6 багц, 20 орчим зүйлийн түүх, соёлын үл хөдлөх үнэт дурсгалууд илэрч, тэдгээрийг түүх соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийн санд бүртгүүлсэн юм. Энэ нь тухайн компани болон ерөнхий үнэлгээнд оролцсон судлаачид хуйвалдаж, хуурамч дүгнэлт үйлдсэн болохыг илчилсэн явдал гэж бид үзэж байна. Цаашилбал энэ нь ноцтой гэмт хэрэг болохыг энд дурьдахыг хүсэв !

**3.2.4.** Ховд аймгийн Мянгад сумын нутаг Халзан бүрэгтэйн цацраг идэвхт ашигт малтмалын орд газарт МНРИК ХХК 2012-2013 онд, мөн 2022-2024 онд өрөмдлөг явуулснаас үүдэлтэйгээр хүрээлэн буй орчинд цацрагийн хордлого, үүсэж хүн, мал амьтан, ургамал, газар амьд байгальд хортой нөлөө үзүүлсэн тухай олон мэдээлэл, баримтууд байгаа. Тэрчлэн хохирогчид нь холбогдох байгууллагуудад гомдол гаргаж, зарим гомдлыг тухайлбал Ховд аймгийн ИТХ-аас өгсөн чиглэлийн дагуу томилогдсон ажлын хэсэг хянан шийдвэрлэхдээ хариуцагч болох “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК-д хохирлыг нөхөн төлж, гомдол барагдуулахыг даалган, албан бичгүүд хүргүүлсэн (Ховд аймгийн ЗДТГ-ын 2024 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 7/3228 (2024 оны 8 дугаар сарын 8-ний өдрийн 4/1444 дугаар бичгүүд) боловч үүнийг биелүүлээгүй байдаг. Цацрагийн хорт нөлөөний тухай зарим мэдээллийг тодруулбал 2012-2013 онд Ховд аймгийн Мянгад сумын төвд болон Халзан бүрэгтэй-н лицензтэй талбайн орчимд нутагладаг айл өрхүүдэд хүний ургийн гажигтай төрөлтийн 4 тохиолдол гарсан нь “МНРИК” ХХК өрөмдлөг хийх үедээ, өрмийн хүдрийг Ховд аймгийн Мянгад сумын төвд тээвэрлэн аваачиж, айлын хашаанд ил задгай хураасны нөлөө, тэрчлэн өрөмдлөгийн нөлөө гэж нутгийн ард олон харддаг. Мөн 2022 онд өрөмдлөг явуулсан талбайгаас 3 км орчимд нутаглаж байсан малчин айлд цацрагийн хордлого илэрч, бог малын үс ноос нь халцарч унан, улаан илэг болж, шарханд баригдаж, 100 гаруй мал хорогдсон, хүмүүсийнх нь биеэр хордлого гарсан. 2023, 2024, 2025 онд ойролцоо нутагладаг малчин өрхүүдийн хотонд малын урагт цацрагийн хордлого хүчтэй илэрч, 10-аад гажигтай төрөлт бүртгэгдсэн. (бүх баримтууд бий) мэрэгчид, зарим төрлийн амьтад устаж үгүй болж буй зэргийг дурьдах хэрэгтэй.

**3.2.5.** Тэрчлэн энэ компани 2017 онд Мянгад сумын Засаг даргаар ажиллаж байсан Б.Даваадорж, Байгаль орчны байцаагч Ө.Хишигтогтох нараар хуурамч тодорхойлолт хийлгэж, тэрхүү тодорхойлолт зэргээ ашиглан, тухайн оны 3 дугаар сарын 22-нд Ашигт малтмал, газрын тосны газраас түгээмэл тархацтай ашигт малтмалын төрлөөр ашиглалтын хоёр тусгай зөвшөөрөл гаргуулж авсан байна. Нягтлаж үзвэл Ашигт малтмал, газрын тосны газраас уг компанид MV-020783, MV-020784 дугаартай тусгай зөвшөөрлүүдийг олгосон захиргааны шийдвэр нь Захиргааны

ерөнхий хуулийн дөчин долоо дугаар зүйлийн 47.1.5, 47.1.6, 47.1.7-д тус тус заасанчлан илт хууль бус шийдвэр болсон бөгөөд мөн хуулийн дөчин долоо дугаар зүйлийн 47.2, 47.3-т зааснаар анхнаасаа хуулийн үйлчлэлгүй, хүчин төгөлдөр бус шийдвэр гэж үзэхээр байна. Тиймээс уг хуулийн 48 дугаар зүйлд зааснаар шийдвэр цуцлагдах ёстой. Энэчлэн тухайн захиргааны шийдвэр нь Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн арван нэг дүгээр зүйлийн 11.1.1, мөн арван хоёр дугаар зүйл, арван найм дугаар зүйлийг зөрчиж гаргасан байх тул гучин долоо дугаар зүйлд заасны дагуу цуцлагдах үндэслэлтэй байна.

**3.2.6. “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК** Халзан бүрэгтэй ууланд ерөмдлөг хийхдээ дээр өгүүлэгдсэн алдаа дутагдлаа засахын оронд санаатайгаар хууль зөрчих үйлдлүүд гаргаж, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөөг 2022 оноос хойш жил болгон хууль бусаар батлуулж ирсэн нь илэрч, 2022 оныхыг улсын байцаагч илрүүлж акт тавьсан бол 2023, 2024 онд энэ талаар БОАЖЯ-нд өргөдөл гомдол хүргэгдсэн атал уг гомдлыг хянан шийдвэрлээгүй орхисон. 2025 оны байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг нь БОУАӨЯ мөн хууль бусаар баталсныг байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд болон сумын ЗДТГ илрүүлж, баталсан шийдвэрийг нь цуцлуулах өргөдөл шаардлага хүргүүлсэн. 2023 оны БОХНС менежментийн төлөвлөгөөг хуурамчаар дүгнэснийг байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд илрүүлж, тухайн ТББ-ууд болон сумын ИТХ-аас БОАЖЯ-нд өргөдөл гомдол хүргэгдсэн ч хянан шийдвэрлээгүй гэхчлэн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийг бүхэлд нь, мөн Ашигт малтмалын тухай хуулийн 35.3.3, 37 дугаар зүйлийн 37.1, 38 дугаар зүйлийн 38.1.1, 38.1.2, 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.1.2, 39.1.3, 39.1.4, мөн 40 дүгээр зүйл, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1, 38.1.2-т тус тус заасан заалтуудыг байнга зөрчиж ирсэн тул Ховд аймгийн Мянгад сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, мөн байгаль орчныг хамгаалах, нийтийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагууд хамтран 2023 оны 11 дүгээр сард БОАЖ-ын яаманд Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5-д заасан үндэслэлээр “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК-д ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргасан Ашигт малтмал газрын тосны газрын шийдвэрийг хүчингүйд тооцуулахтай холбоотой дүгнэлт гаргуулах өргөдөл, холбогдох материал, нотлох баримтуудыг хүргүүлсэн. Улмаар тус яамнаас ирсэн хариу зөвлөмжийн дагуу шаардлагатай нэмэлт материал, нотлох баримтуудыг БОАЖЯ-ны яамны сайдын 2020 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн А/402 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл цуцлуулах санал хүргүүлэх журам”д нийцүүлэн, үе шаттайгаар бүрдүүлж, Ховд аймгийн Засаг даргаар уламжлуулж, 4 удаагийн давтамжаар, хамгийн сүүлд бүх баримт материал, нотлох баримтуудыг дахин шинээр бүрдүүлж, Ховд аймгийн Засаг даргын 2025 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 1/992 дугаар албан бичгээр уламжлуулж хүргүүлсэн. Гэвч уг өргөдлийг хэлэлцүүлж шийдэх бүрэн бололцоо хангагдсаныг БОУАӨЯ үл хайрхан, шийдэхийг хүсэхгүй байх тул (хэлэлцэх шийдэх хуулийн хугацаа хэтэрсэн) Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн



14.1.1, 14.2-д заасныг үндэслэн, Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд энэхүү нэхэмжлэлийг гаргаж байна.

**3.2.7. Захиргааны ерөнхий хуулийн дэчин долоо дугаар зүйлийн 47.1.5, 47.1.6, 47.1.7, 47.2, 47.3, мөн 48 дугаар зүйл, Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5, 56.1.7, Цөмийн энергийн тухай хуулийн холбогдох заалтууд, Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх тухай хуулийн 1 дүгээр зүйл, 4 дүгээр зүйл, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн арваннэгдүгээр зүйлийн 11.1.1, мөн арванхоёрдугаар зүйл, арваннаймдугаар зүйл, гучиндолоодугаар зүйлийг тус тус үндэслэн Ховд аймгийн Мянгад сумын нутаг дахь Халзан бүрэгтэйд “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК-ны эзэмшиж байсан 2797Х, мөн одоо эзэмшиж байгаа 12335А, 6911А, 020783А, 020784А ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийг олгохоор шийдвэрлэсэн Ашигт малтмал газрын тосны газрын шийдвэрүүд нь илт хууль бус болохыг тогтоож, улмаар уг захиргааны шийдвэрүүдийг хүчингүй болгож шийдвэрлэж өгнө үү. Энэхүү нэхэмжлэлд Захиргааны хэрэг үүсгэсэн цагаас эхлэн тухайн Захиргааны шийдвэрүүдийн биелэлтийг түдгэлзүүлэхийг нэхэмжлэгчид болон тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид мөн хүсэж байна.**

**Дөрөв. Нэхэмжлэлд хавсаргасан баримтууд:**

1. Ховд аймгийн Мянгад сумын ИТХ болон төрийн бус байгууллагуудаас БОАЖЯ-нд 2023 оны 11 дүгээр сард тусгай зөвшөөрөл цуцлуулах дүгнэлт гаргуулах тухай өргөдөл хүргүүлсэн албан бичгийн хуулбар, өргөдлийн хуулбар;

2. Тусгай зөвшөөрөл цуцлуулах дүгнэлт гаргуулах тухай өргөдлийг 2025 оны 5 дугаар сарын 9-ны өдрөөр БОУАӨ-ийн яаманд шинээр хүргүүлсэн Ховд аймгийн Засаг даргын албан бичгийн хуулбар, өргөдлийн хуулбар;

3. 2023, 2024 онд Ховд аймгийн Засаг даргаас БОАЖЯ-нд удаа дараа хүргүүлсэн өргөдлийн тухай албан бичгийн хуулбарууд;

4. БОУАӨ-ийн яамнаас ирүүлсэн бичгийн хуулбар;

5. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, эсвэл (тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөх хүсэлт бичиг);

6. Ашигт малтмал газрын тосны газраас ирүүлсэн “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК-ны эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүдийн тухай лавлагаа;

7. Хохирсон иргэний гомдлын мөрөөр байгуулагдан ажилласан аймгийн Мал эмнэлгийн газрын ажлын хэсгийн дүгнэлтийн хуулбар;

8. Мал эмнэлгийн төв лабораторийн шинжилгээний дүгнэлтийн хуулбар;

9. Аймгийн ЗДТГ-аас МНРИК компанид хүргүүлсэн иргэний хохирол барагдуулах тухай албан бичгүүдийн хуулбар;

10. Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн № 1/877 дугаар дүгнэлт зөвлөмжийн хуулбар;

11. Цөмийн энергийн комиссоос Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хүргүүлсэн 2023 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 1/24 дугаартай албан бичгийн хуулбар;

12. Цөмийн энергийн комиссын ажлын албанаас “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК-д болон Ховд аймгийн Засаг даргад хүргүүлсэн 2023 оны 1 дүгээр сарын 25-ний өдрийн 1/45 дугаартай албан шаардлагын хуулбар;

13. Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Геологи, уул уурхайн хяналтын улсын ахлах байцаагчийн 2011 оны дүгнэлтийн хуулбар

14. Төрийн бус байгууллагуудаас 2024 оны 4 дүгээр сард БОАЖЯ-нд хүргүүлсэн гомдол, албан бичгээр (хуулбар) Хөндлөнгийн үнэлгээний багаас гаргасан дүгнэлийн хуулбарын хамт;

15. Мянгад сумын ИТХ-аас 2024 оны 5 дугаар сард БОАЖЯ-нд хүргүүлсэн гомдол, албан бичгээр (хуулбар) хөндлөнгийн үнэлгээний багаас гаргасан дүгнэлийн хуулбарын хамт;

16. Соёлын өвийн үл хөдлөх дурсгалуудыг шинээр илрүүлэн бүртгэлжүүлсэн баримтын хуулбар;

17. Шүүхэд нэхэмжлэл гаргахаар шийдвэрлэсэн, итгэмжлэгдсэн төлөөлөгч томилсон тухай Ховд аймгийн Мянгад сумын ИТХ-ын тогтоол;

18. Шүүхэд нэхэмжлэл гаргахаар шийдвэрлэсэн, итгэмжлэгдсэн төлөөлөгч томилсон тухай Ховд аймгийн Мянгад сумын Засаг даргын шийдвэр, итгэмжлэл;

19. Шүүхэд нэхэмжлэл гаргахаар шийдвэрлэсэн, итгэмжлэгдсэн төлөөлөгч томилсон тухай хамтран нэхэмжлэгч ТББ-уудын шийдвэр, итгэмжлэл, хуралдааны тэмдэглэл;

20. Ховд аймгийн ЗДТГ-ын 2023 оны 1/22 дугаар мэдэгдэх бичгийн хуулбар;

21. Ховд аймгийн Засаг даргаас 2011, 2012 онд Ашигт малтмалын газар, Кадастрын хэлтэс, Байгаль орчин ногоон хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн албан бичгийн хуулбарууд;

22. Монголиан нэшнл рийр ийрт корп компани 2024 онд “Баялаг ундрах говь” компаниар хийлгэсэн цацрагийн хэмжилт шинжилгээний дүн, материалд МУИС-ийн баруун бүсийн сургуулийн судлаачдын хийсэн магадлан шинжилгээний харьцуулсан үр дүнгийн хуулбар;

23. Мянгад сумын ИТХ-ын даргын 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 1/40 дугаар албан бичгийн хуулбар;

24. Мянгад сумын ИТХ-ын даргын 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 1/18 дугаар албан бичгийн хуулбар;

25. Ховд аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1/443 дугаар албан бичгийн хуулбар;

26. Ховд аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 1/1913 дугаар албан бичгийн хуулбар;

27. Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 3/2460 дугаар албан бичгийн хуулбар;

28. Монгол Улсын Их Хурлын даргын 2025 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 03/4354 дүгээр албан бичгийн хуулбар;

29. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн ТГ/980 дугаар албан бичгийн хуулбар.

30. Байгаль хамгаалах болон нийтийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудаас Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны сайд болон хэлтсийн дарга Ч.Хандсүрэн, шинжээч З.Цогбаяр нарт хүргүүлсэн мэдэгдэл, шаардлагын хуулбар.

31. Бүрдүүлбэр хангасан тухай тайлбар, уг тайлбарт авагдсан хавсралтуудын хамт.

#### НЭХЭМЖЛЭЛ ГАРГАСАН:

Нэхэмжлэгчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч:

Г.ТӨРМӨНХ

Г.НЯМДАВАА

С.ЦЭРЭНЧИМЭД

Б.ГАНТӨМӨР





МОНГОЛИАН НЭШНЛ РИЙР ИЙРТ  
КОРП ХХК-НЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
А ЦОЛМОН ТАНАА

ХОВД АЙМАГ  
МЯНГАД СУМЫН ИРГЭДИЙН  
ТОЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

84100 Баянхошуу, Мянгaд сум, Ховд аймаг  
E-mail: myangadsumkhural@gmail.com

2025.04.25 № 1/18  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Мянгaд сумын нутаг дахь Халзан бүрэгтэйд танай компаний эзэмшиж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хуульд нийцэж байгаа эсэхийг хянуулж дүгнэлт гаргуулах, мөн байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ хөсөрдүүлсэн зөрчлүүд хийгээд танай компаний үйл ажиллагааны улмаас хүрээлэн байгаа орчин, хүн, амьтан, ургамал, хөрс усанд нөлөөлж буй сөрөг нөлөөлөл, хохирлын талаар Байгаль орчныг хамгаалах төрийн захиргааны төв байгууллагад өргөдөл гомдол гаргасан тухай танайд 2023 онд мэдэгдэж байсан.

2024 оны сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан Мянгaд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь уг асуудлыг үргэлжлүүлэн хариуцаж, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яаманд гаргасан гомдлыг хянан шийдвэрлүүлэхээр ажиллаж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Ийм учраас төрийн захиргааны төв байгууллагад гаргасан уг өргөдөл гомдлыг нэг мөр хянан шийдвэрлэж дуустал манай сумын нутаг Халзан бүрэгтэйд болон сум орон нутагт аливаа үйл ажиллагаа явуулахгүй байхыг үүгээр мэдэгдэж байна.

ДАРГА



Б.ИДЭРЗАЯА

Холбогдох утасны дугаар 70432041, 88435611, 88817870, 99821463

Имэйл хаяг: [Altaibidniishuteen@gmail.com](mailto:Altaibidniishuteen@gmail.com),  
[khovdiintoli@gmail.com](mailto:khovdiintoli@gmail.com)

**БАЙГАЛЬ ОРЧИН УУР АМЬСГАЛИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН  
ЯАМНЫ САЙД Б.БАТБААТАР ТАНАА**

**Мэдэгдэл, шаардлага хүргүүлэх тухай**

Танай яамны Байгаль орчны үнэлгээ аудитын хэлтсийн дарга Ч.Хандсүрэн, ХБОБЗГ-ын ахлах шинжээч З.Цогтбаяр нар Ховд аймгийн Мянгад сумын нутаг Халзан бүрэгтэйд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч гэх "Монголиан нэшнл рийр ийрт корп" ХХК-ны 2025 онд тус газарт хайгуул өрөмдлөг явуулах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2025 оны 5 дугаар сард баталж, гарын үсэг зуржээ.

Гэтэл энэ нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хянан батлах тайлагнах журмын хоёрдугаар зүйлийн 2.1, 2.2, 2.7, гуравдугаар зүйлийн 3.1, 3.3, 3.4, дөрөвдүгээр зүйлийн 4.11, 4.15, 4.16, тавдугаар зүйлийн 5.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн, Захиргааны ерөнхий хуулийн дөчиндолоо дугаар зүйлийн 47.1.5, 47.1.6, 47.1.7-д заасанчлан илт хууль бус шийдвэр болсон байна.

Мөн танай яаманд Мянгад сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, нэр бүхий төрийн бус байгууллагуудаас 2023 оны 11 дүгээр сард анх хүргүүлж, улмаар танайхаас ирүүлсэн зөвлөмж шаардлагуудын дагуу холбогдох материал нотлох баримтуудыг 4 удаагийн давтамжаар, БОАЖ-ын сайдын 2020 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн А/402 дугаар тушаалаар батлагдсан тусгай зөвшөөрөл цуцлуулах өргөдлийг хэлэлцэж шийдвэрлэх журманд нийцүүлэн бүрэн бүрдүүлж, Ховд аймгийн Засаг даргаар уламжлуулан 2025 оны 5 дугаар сард хүргүүлсэн. Уг асуудлыг танай яамнаас хэлэлцэж шийдвэрлэхийн тулд Захиргааны ерөнхий хуулийн 96 дугаар зүйлийн 96.1-д заасны дагуу өргөдөл гаргагчийн хүсэлтийг үндэслэн, тусгай зөвшөөрлийг олгосон захиргааны шийдвэрийг түдгэлзүүлж, уг аж ахуйн нэгжид ямар нэг зөвшөөрөл олгох ёсгүй байтал 2025 оны гэх БОХНС менежментийн төлөвлөгөөг нь ийнхүү хууль бусаар батлаж өгсөн байна.

Ийм учраас Захиргааны ерөнхий хуулийн дөчин найм дугаар дугаар зүйлийн 48.1, мөнхүү дөчин ес дүгээр зүйлд тус тус заасны дагуу энэхүү хууль бус захиргааны актыг цуцлах, хүчингүй болгохыг шаардаж, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дөрөв дүгээр зүйлийн 4.5, гучин хоёр дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, мөн Захиргааны ерөнхий хуулийн 92, 93 дугаард зүйлд заасны дагуу энэхүү мэдэгдлийг хүргүүлж байна. Энэхүү мэдэгдэл, шаардлагыг бид 2025 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн огноотойгоор шуудангаар хүргүүлсэн боловч яамны нэрийг хуучин нэршлээр бичсэн учир буцаагдсан бөгөөд, нэр хаягийг засаж дахин хүргүүлж байна.

Уг шийдвэр илт хууль бус болохыг бид нотлох баримтуудаар бүрэн гэрчлэнэ гэдгийг мэдэгдье.

Энэхүү шаардлагыг даруй биелүүлээгүй нөхцөлд асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэхийг сануулж байна.

"ХОВДЫН ТОЛЬ СОНИН" НҮТББ  
ТЭРГҮҮН Г.ТӨРМӨНХ



"АЛТАЙ БИДНИЙ ШҮТЭЭН" НҮТББ  
ТЭРГҮҮН Б.ГАНТӨМӨР



"ЭЛГЭН НУТАГ СУТАЙ" НҮТББ  
ТЭРГҮҮН Д.ЦЭДЭНБАЛ



"МЯНГАДЫН МЯНГАН МОРЬТОН" ТББ  
ТЭРГҮҮН М.БАЯНЗУЛ



"ШИНЭ ЭВЛЭЛ ОНСХ" НҮТББ  
УЗ-ЫН ДАРГА Г.ТӨРМӨНХ




АРИУН ЗАМНАЛТ АХМАДУУД ТББ  
ТЭРГҮҮН Д.БАТСУУРЬ



"НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА" ТББ  
С.ӨЛЗИЙЖАРГАЛ



МОНГОЛЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ  
ХАМГААЛАХ ХОЛБООНЫ ХОВД  
АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ  
ТЭРГҮҮН ТЭГШЖАРГАЛ



2025 оны 5 дугаар сарын 28

Ховд аймаг

## АЖ ҮЙЛДВЭР ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ САЙД Ц.ТУВААН ТАНАА

Танай зөвлөмж бичигтэй холбоотой мэдэгдэл хүргүүлэх тухай

Танай яамнаас, Салбар хяналтын газрын дарга Д.Даваадорж гэсэн нэрээр ирүүлсэн 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 11/1505 дугаар зөвлөмж гэх бичгийн тухай Ховд аймгийн Мянгад сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас бидэнд мэдэгдэв.

Ховд аймгийн Мянгад сумын нутаг "Халзан бүрэгтэй"-д газрын ховор элементийн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж буй "Монголиан нэшнл рийр ийрт корпорейшн" ХХК-ны тусгай зөвшөөрөл нь хууль зөрчиж олгогдсон байх үндэслэлтэй, мөн тухайн компани нь байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөөг удаа дараа хууль бусаар батлуулсан, уг төлөвлөгөө нь хууль журмын шаардлага хангаагүй, хэрэгжилтийг хуурамчаар дүгнэсэн гэх үндэслэлүүдээр Ховд аймгийн Мянгад сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас, мөн нэр бүхий төрийн бус байгууллагуудаас 2023 оны 11 дүгээр сар, 2024 оны 5 дугаар саруудад Байгаль орчны асуудал эрхлэсэн төрийн захиргааны төв байгууллагад өргөдөл гомдлууд гаргаж, холбогдох баримт материалуудыг Ховд аймгийн Засаг даргаар уламжлуулан хүргүүлсэн. Шийдвэрлэх асуудал нь хүлээгдэж байгаа.

"Монголиан нэшнл рийр ийрт корпорейшн" ХХК-ний захирал А.Цолмон нь уг өргөдлийг зөвхөн "Ховдын толь сонин" иргэний нийгмийн байгууллагаас гаргасан мэтээр та бүхнийг зориудаар төөрөлдүүлсэн бичиг хүргүүлсэн байна. Тэрхүү бичгийг үндэслэн танай яамны газрын дарга Д.Даваадорж нь Ховд аймгийн Мянгад сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд "зөвлөмж" гэсэн утгатай бичиг хүргүүлэхдээ төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх хүртэл гэсэн шалтгаанаар аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хэн нэгэн зогсоох эрхгүй, хууль бус мэтээр бичсэн нь Төрийн захиргааны төв байгууллагын газрын дарга хүн нэгэн хувийн компаний эрх ашигт үйлчилж, ёс зүйгүй, хууль бус үйлдэл гаргасан зохисгүй зүйл гэж бид харж байна !

Захиргааны ерөнхий хуулийн 96 дугаар зүйлийн 96.1-д нийтийн эрх ашигт харшилсан үндэслэлээр өргөдөл гомдол гаргасан нөхцөлд захиргааны үйл ажиллагааны оролцогч болон эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр гомдлыг хянан шийдвэрлэх эрх бүхий захиргааны байгууллага захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлнэ гэж заасан байдаг.

Мөн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулиар нутгийн удирдлага, захиргааны байгууллага нь тухайн нэгжийн нутаг дэвсгэр дэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хууль бус аливаа үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээ авах эрхтэй байдаг.



Хуулийн эдгээр үндэслэлд тулгуурлан Ховд аймгийн Мянгад сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тус компанид бичиг шаардлага хүргүүлсэн гэдгийг үнэн мөнөөр нь ойлгуулахын тулд энэхүү бичгийг хүргүүлж байна.

Ховд аймгийн Мянгад сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас "Монголиан нэшнл рийр ийрт корпорейшн" ХХК-д хүргүүлсэн мэдэгдэл нь хууль ёсны гэдгийг танд мэдэгдэж байна.

Мөн танай яамны газрын дарга Д.Даваадоржийн ирүүлсэн уг бичигт Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс эш татжээ. Хөтөлбөрийн тэрхүү хэсэг нь Халзан бүрэгтэйд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид зориулагдсан зүйл биш бөгөөд Засгийн газрын хөтөлбөрөөс нэгэн хувийн компаний эрх ашигт зориулж эш татах нь зохимжгүй зүйл болохыг сануулж байна.

Аливаа үйл ажиллагаа хуулийн дагуу явагдах ёстой бөгөөд, яам ч, нутгийн удирдлага захиргааны байгуулага ч, аливаа аж ахуйн нэгж ч, төрийн бус иргэний нийгмийн байгууллагууд ч хуулийн дагуу ажиллах ёстой. Хууль ёс нь алагчлалгүй, ялгаварлан гадуурхалтгүй, хуйвалдаан, заль мэхээс ангид, тэгш үйлчилэх ёстой гэдгийг та бүхэнд анхааруулж байна.

"ХОВДЫН ТОЛЬ СОНИН" ТББ-ЫН  
ТЭРГҮҮН Г.ТӨРМӨНХ

"АЛТАЙ БИДНИЙ ШҮТЭЭН" ТББ-ЫН  
ТЭРГҮҮН В.АНТӨМӨР

"ХӨШӨӨТИЙН АХМАД УУРХАЙЧДЫН  
ХОЛБОО" ТББ-ЫН ТЭРГҮҮН

"МЯНГАДЫН МЯНГАН МОРЬТОН"  
ТББ-ЫН ТЭРГҮҮН М.БАЯНЗУЛ

Д.ЦЭДЭНБАЛ

"ШИНЭ ЭВЛЭЛ" - "ОРОН НУТГИЙН СЭТГҮҮЛДЧИЙН ХОЛБОО"  
ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Г.ТӨРМӨНХ



## Газрын ховор элементийн Халзан бүрэгтэй төслийн талаарх Төлсөн Авснаа Нийтэл (ТАН) иргэний нийгмийн эвслийн байр суурь

“Төлсөн авсанаа нийтэл” эвсэл (цаашид ТАН эвсэл гэх) нь 2006 он байгуулагдсан, эрдэс баялгийн салбарт ил тод, нээлттэй, хариуцлагатай сайн засаглалыг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилго бүхий, 30 гаруй төрийн бус байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн иргэний нийгмийн эвсэл юм. ТАН эвсэл нь Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ын албан ёсны нэг оролцогч тал бөгөөд Монгол Улсад уг санаачилгыг хэрэгжүүлэх Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн гишүүнээр тасралтгүй, үр нөлөөтэй ажиллаж ирлээ.

“Халзан бүрэгтэй” төслийн явцад Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа олон хууль тогтоомжийг зөрчиж байгаа нь цаашид энэ төсөл хариуцлагатайгаар хэрэгжинэ гэх итгэл төрүүлэхгүй байна.

### Тусгай зөвшөөрөл нь хууль бус болох талаар:

- Цөмийн энергийн тухай хууль батлагдахаас өмнө авсан тусгай зөвшөөрлүүдийг шинэчлэн бүртгүүлээгүй: Халзан Бүрэгтэй дэх “Монтем” ХХК-ны эзэмшиж байсан 2797Х тоот хайгуулын тусгай зөвшөөрөл анх 2000 онд, 12335А тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл 2001 онд<sup>1</sup>, 6911А тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл 2004 онд тус олгогджээ. Эдгээр тусгай зөвшөөрлүүд нь 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон бөгөөд 2011 онд “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК шилжүүлэн авчээ. Харин Халзан Бүрэгтэй ордод агуулагдах газрын ховор элемент нь цацраг идэвхт ашигт малтмал болохын хувьд<sup>2</sup> 2009 онд батлагдсан Цөмийн энергийн тухай хуулийн дагуу нэг жилийн дотор шинэчлэн бүртгүүлэх ёстой байв<sup>3</sup>. Учир нь цацраг идэвхт ашигт

<sup>1</sup> Уг тусгай зөвшөөрөл нь 4003А дугаартай байсан боловч гэрчилгээг үрэгдүүлсний улмаас 2007 оны 1 сарын 22-ны өдөр 12335А дугаартайгаар шинэчлэн авсан болно.

<sup>2</sup>Цөмийн энергийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 "цөмийн бодис" гэж цөмийн материал болон цөмийн технологид хэрэглэгдэх уран, торийн бүлийн цацраг идэвхт изотоп, газрын ховор элемент агуулсан бодисыг" ойлгоно.

Цөмийн энергийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15. "цөмийн эх үүсвэр материал" гэж цөмийн түлшний материалыг гарган авах уран, торийн хүдэр, газрын ховор элемент зэрэг түүхий эд материалыг ойлгоно.

<sup>3</sup> Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйл. "Цөмийн энергийн тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө олгосон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2009 оны 11 дүгээр сарын 15-ны дотор уг хуульд заасан нөхцөл, журмын дагуу шинэчлэн бүртгэнэ."

малтмалын үйл ажиллагаанд аюулгүй байдлыг хангаж, хүрээлэн буй орчин, хүн амыг сөрөг нөлөөнөөс хамгаалахын тулд ердийн ашигт малтмалаас илүү өндөр шаардлага тавьдаг. Тодруулбал, Цөмийн энергийн тухай хуулиар цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөлд Ашигт малтмалын тухай хуульд зааснаас даруй 18 нэмэлт шаардлага тогтоосон бөгөөд түүнийг хангаж буйг нотлох нийт 9 баримт бичгийг тусгай зөвшөөрөл авах үедээ бүрдүүлсэн байх ёстой.

Гэтэл Халзан бүрэгтэй төслийн тусгай зөвшөөрлүүдийг Цөмийн энергийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн шинэчлэн бүртгүүлээгүй нь нэн эрсдэлтэй бөгөөд дээрх тусгай зөвшөөрлүүдийг хүчин төгөлдөр бус гэж үзэх хангалттай үндэслэл юм<sup>4</sup>. Энэ нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргын зөвлөмжөөр байгуулагдсан “Халзан бүрэгтэй орд газарт хяналт шалгалт хийж, санал дүгнэлт боловсруулах Ажлын хэсгийн тайлан”-аар нотлогдож байна.

- Тусгай зөвшөөрлийг хууль бусаар шилжүүлсэн талаар: Монтем ХХК 2008 онд тусгай зөвшөөрлүүдээ Худалдаа хөгжлийн банк-д барьцаалан зээл авсан боловч төлж чадаагүй. Ингээд ХХБ 2011 онд өөрийн үүсгэн байгуулсан “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК-ний нэр дээр 2797Х, 6911А, 12335А тоот тусгай зөвшөөрлүүдийг шилжүүлэн авчээ. Энэ нь Цөмийн энергийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан “Тусгай зөвшөөрөл болон энэ хуулийн 15.2.1, 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг худалдах, бэлэглэх, барьцаалах болон өөр бусад хэлбэрээр бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлэхийг хориглоно” гэсэн шаардлагыг зөрчсөн байна.
- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг зөрчиж буй талаар: 2797Х тоот хайгуулын талбайд соёлын өвийн дурсгал тогтоогдсон тул Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.7-д заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцлах нөхцөл бүрджээ. Тодруулбал, 2012 онд хийгдсэн тус төслийн Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний тайланд “тусгай зөвшөөрлийн талбайд соёлын дурсгалт зүйл байхгүй” гэж дүгнэсэн боловч 2022 онд тус талбайд хийгдсэн археологийн судалгаагаар 10 гаруй соёлын өвийн үл хөдлөх дурсгал илэрч, Соёлын өвийн үл хөдлөх дурсгалын улсын бүртгэлд албан ёсоор бүртгэгджээ. Ашигт малтмалын тухай хуулийн 56 зүйлийн 56.1.7-д зааснаар хайгуулын талбайд соёлын өв байгаа нь тогтоогдсон бол тусгай зөвшөөрлийг цуцлах зохицуулалттай. Тэрчлэн Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээгээр соёлын өв байхгүй гэж дүгнэн 2022 оныг хүртэл хайгуулын үйл ажиллагаа явуулсан нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.2-д заасан археологийн судалгаа хийлгэлгүйгээр уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглох заалтыг зөрчсөн байна.

#### Цөмийн энергийн тухай хуулийг зөрчиж буй талаар:

- Тухайн төсөл болон түүнийг хэрэгжүүлэгч нь Цөмийн энергийн тухай хуульд заасан дараах шаардлагуудыг хангахгүй тул Халзан бүрэгтэйн газрын ховор элементийг эдийн засгийн эргэлтэд оруулахад хүндрэлтэй талаар дээрх Ажлын хэсэг ийнхүү дүгнэжээ.

---

<sup>4</sup> Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл. Энэ хуульд заасны дагуу цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг шинэчлэн бүртгүүлээгүй бол түүнийг хүчингүй болсонд тооцно.

- “Газрын ховор элемент боловсруулах технологи нь их хэмжээний хаягдал үүсгэхээр байна. Үүний дотор цацраг идэвхт хаягдал багагүй хэмжээгээр гарах бөгөөд төслийн үндсэн баримт бичгүүдэд энэ талаар огт тусгаагүй, энэ талаар тодорхой ойлголтгүй байна” гэжээ. Энэ нь төслийн үйл ажиллагаа Цөмийн энергийн тухай хуулийн 17.1.1-д заасан” техникийн болон аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан байх” шаардлагыг хангаж чадахгүй байгааг харуулж байна.
- Ажлын хэсэг “Технологийн хувьд дэлхийн хэмжээнд тогтсон сайн туршлага нэвтрүүлэхээр сонголт биш байна” гэж үзжээ. Энэ нь Цөмийн энергийн тухай хуульд заасан “цацраг идэвхт ашигт малтмал олборлох, боловсруулах олон жилийн туршлагатай байх<sup>5</sup>”, “цацраг идэвхт ашигт малтмалын ордын нөөцийг бүрэн ашиглах тэргүүний технологитой байх<sup>6</sup>”, “цацраг идэвхт ашигт малтмалыг боловсруулах, ашиглахдаа эдийн засгийн илүү үр ашигтай, дэвшилтэт технологи ашигладаг байх<sup>7</sup>” шаардлагуудыг төсөл хэрэгжүүлэгч компани хангаж чадахгүй байгааг харуулж нийцэхгүй байна.
- Мөн Ажлын хэсгийн тайланд “Ордыг ашиглахад гарах зардал, олох орлогыг байгаль орчныг нөхөн сэргээх, хаягдлын менежментийг олон улсын болон үндэсний дүрэм, журам, стандартын дагуу хийхэд гарах зардалтай харьцуулсан судалгаа байхгүй. Өмнө хийгдсэн судалгаагаар тус ордын хувьд хариуцлагатай уул уурхай явуулахад төвөгтэй, нөхөн сэргээх, хаягдлын менежментийн зардал нь өндөр учраас ордыг ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиггүй гэж үзсэн байна” гэжээ. Энэ нь Цөмийн энергийн тухай хуулиар тогтоосон “цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалт хийх санхүүгийн чадавхтай байх<sup>8</sup>”, “байгаль орчны болон биологийн нөхөн сэргээлт хийх санхүүгийн чадавхтай байх<sup>9</sup>” шаардлагыг хангахгүй болохыг харуулж байна.
- Үндэсний аюулгүй байдлын Нарийн бичгийн даргын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн Халзан бүрэгтэй орд газрын талбайд хийгдсэн цацраг идэвхт изотоп, түүний идэвхжилийг тодорхойлох шинжилгээгээр маш олон үзүүлэлт өндөр буюу хяналтаас чөлөөлөх түвшний утгаас хэтэрсэн байгааг тогтоож, компанид тодорхой шаардлагууд хүргүүлснийг<sup>10</sup> болон эдгээр шаардлагын хэрэгжилт одоо болтол тодорхойгүй байгааг анхаарах нь зүйтэй.

Байгаль орчны хууль тогтоомжийн зөрчлийн талаар:

- 1997 оны болон 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн аль алинд заасны дагуу<sup>11</sup> хайгуулын тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль

<sup>5</sup> Цөмийн энергийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.5 дахь заалт

<sup>6</sup> Цөмийн энергийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.6 дахь заалт

<sup>7</sup> Цөмийн энергийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.7 дахь заалт

<sup>8</sup> Цөмийн энергийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт

<sup>9</sup> Цөмийн энергийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2 дахь заалт

<sup>10</sup> Цөмийн энергийн комиссын Ажлын албаны 2022 оны 11 сарын 30-ны өдрийн 1/877 тоот албан бичиг болон Улсын байцаагчийн дүгнэлт

<sup>11</sup> 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 " Хайгуулын лиценз эзэмшигч нь Байгаль орчны хяналтын алба болон тухайн нутгийн захиргаатай зөвшилцөн



орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) батлуулах ёстой атал 2022 оныг хүртэл БОМТ төлөвлөгөөгүй явж ирсэн. Анх удаа 2022 онд БОМТ батлуулсан боловч уг төлөвлөгөө нь Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (БОНБҮтХ), Захиргааны ерөнхий хуулийг зөрчсөн хууль бус болохыг 2023 оны 4 сарын 29-ны УУХҮЯ-ны улсын байцаагчийн дүгнэлтээр тогтоож хүчингүй болгожээ.

- Ийнхүү хүчингүй болсон БОМТ-г 2023 оны 5 сард БОАЖЯ дахин хянаж баталсан боловч мөн л Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг хянан батлах, тайлагнах, хяналт тавих журмыг<sup>12</sup> зөрчин өмнөх жилийн БОМТ-ийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнээгүй, Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлийг зөрчин Сонсох ажиллагаа хийлгүй батлагдсан зөрчилтэй болно.

#### Олон улсын хэм хэмжээ

2011 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл (ХЭЗ) хүний эрхийг “хамгаалах, хүндлэх, сэргээх” НҮБ-ын суурь зарчмыг хэрэгжүүлэх “Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчмууд”-ыг баталж, гишүүн орнуудад хэрэгжүүлэхийг уриалсан. 2015 онд НҮБ-ын ХЭЗ Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын хоёр дахь удаагийн тайланг хэлэлцэх үеэр Нидерланд Улсаас Бизнес ба Хүний эрхийн үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлж бизнесээс хүний эрхэд учруулж буй сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж өгсөн. МУ-ын Засгийн газар энэ зөвлөмжийг хүлээн авч ГХЯ-ны дэргэд 2016 онд Бизнес ба хүний эрхийн үндэсний төлөвлөгөө боловсруулах Ажлын хэсэг байгуулж ажиллуулсан. 2020 онд тус Ажлын хэсгийг төр, төрийн бус болон хувийн хэвшлийн төлөөлөл бүхий 61 гишүүнтэй болгон шинэчлэн байгуулсан. 2023 оны 6 сарын 14-нд “Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027)”-г баталсан.

Эрчим хүчний шилжилттэй холбогдуулан зах зээлийн эрэлт нь хурдтай нэмэгдэж буй энэ цаг үед, кобальт, литий, зэс болон газрын ховор элементүүдийн нөөц ихтэй хөгжиж буй улсуудад тэдгээрийг олборлон үр шимийг нь иргэддээ хүртээх, эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг сахих, байгаль орчны тэнцвэрийг хадгалах, нийгмийн хөгжлийг хэрэгжүүлэхэд олон асуудал тулгамдаж байна. Эдгээрийг шийдэх зорилгоор Эрчим хүчний шилжилтийн чухал ашигт малтмалын үйл ажиллагааны НҮБ-ын Удирдамжийг 2024 онд боловсруулан хөгжингүй болон хөгжиж буй улс орнуудад хэрэгжүүлэхийг уриалсан. Энэ удирдамжаар хүний эрх, байгаль орчин, шударга ёс, нийтэд хүртээмжтэй хөгжил, шударга хариуцлагатай хөрөнгө оруулалт, ил тод хариуцлагатай авлигаас ангид засаглал, энх тайван аюулгүй байдлын төлөө хамтран ажиллах долоон зарчмыг НҮБ-ын гишүүн орнууд, үндэсний болон үндэстэн дамнасан бизнесийн байгууллагууд

---

хайгуулын лиценз авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг бэлтгэж боловсруулна”.

2006 оны Ашигт малтмалын тухай 38 дугаар зүйлийн 38.1.1 "тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах."

<sup>12</sup> Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг хянан батлах, тайлагнах, хяналт тавих журмын 1.6, 2.9, 3.1, 3.3, 3.4 дэх заалтууд.

хэрэгжүүлэх юм. Удирдамж хүний эрхийг цөмд нь тавьж, улс орнуудаас хүний эрхийг хамгаалах, хүндэтгэх, хэрэгжүүлэхээр олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргүүдэд тулгуурласан.

Уурхайн төслүүд, ялангуяа шилжилтийн чухал ашигт малтмалын олборлолт, боловсруулалт нь нутгийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, амьд явах, мэдээлэл авах зэрэг олон эрхийг дахин дахин зөрчих өндөр магадлалтай, хамрах хүрээ өргөн, үзүүлэх нөлөөлөл нь ноцтой байх эрсдэлтэйг үргэлж анхаарч байгаль орчинд халгүй технологи хэрэглэх, эдийн засгийн үр шим нь өндөр, хөгжилд бодитой хувь нэмэр оруулах төслийг л хэрэгжүүлэх шаардлагатай.

Халзан бүрэгтэй төслийг хэрэгжүүлж буй “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК нь бизнесийн эрх ашгийнхаа үүднээс хүний эрхийг болон нийтийн эрх ашгийг зөрчих, илт түрэмгийлэх хандлагыг гаргасаар ирсэн. Тухайлбал байгаль орчны үнэлгээ, төлөвлөгөөнд санал авч, иргэдээр зөвшөөрүүлэхийн тулд нөлөөллийн бүсийн иргэд, айл өрхүүдэд албаар эд зүйл өгөх гэж тулгах, нэг талыг барьсан суртал ухуулга хийж бизнесийн эрх ашгаа хүчээр тулгах (нутгийн иргэд гэрчилдэг), зарим хэвлэл мэдээлэлд мөнгө төлж, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын дүгнэлт зэргийг, албаар гүтгэж худал мэдээлэл тараалгах (энэ талаар ЦЭК зэрэг мэргэжлийн байгууллагаас тус компанид шаардлага хүргүүлсэн асуудал бий), үзэл бодлоо гаргасан, шүүмжилсэн, эсэргүүцэл илэрхийлсэн иргэдээс их хэмжээний мөнгө нэхэмжилж, шүүх, цагдаагийн үүд сахиулах (ийм ажиллагаа олон удаа давтагдаж байгаа). Энэ төсөл нь нутгийн болон бүс нутгийн иргэдээс хүлээн зөвшөөрөгдөхгүй байгаа, АМТХ-ийн дагуу орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулаагүй атлаа Орон нутагт Нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжих нэрийдлээр оюутны сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно, малчдад хүүгүй зээл олгоно гэх зэргээр зориудаар урхидах булхай луйврын сэдэл, үйл ажиллагааг явуулсаар байгаа, мөн орон нутгийн төр, захиргааны байгууллагатай хууль зөрчиж элдэв тохироо хийх, гэрээ хэлцэл үүсгэх замаар авлигын шинжтэй асуудлууд үүсгэх гэх мэтээр нийтлэг хэм хэмжээнд харшилсан зүйлүүдийг байнга явуулсаар байгаа.

“Халзан бүрэгтэй” төслийн хэрэгжилтэд дараах эрсдэлүүд үүсэж болзошгүй байна. Үүнд:

Нэг.

Байгалийн баялгийн нөөцийг тав ангилдаг ба Халзан бүрэгтэй орд нь байж болзошгүй буюу хамгийн бага ангилалд багтжээ. Ийм учраас 1,2 сая тонн гэж тогтоосон нөөцийн тоо хэмжээ доошлох магадлалтай. Тус ордын газрын ховор элементийн агуулга нь 0.4 хувьтай бөгөөд 5-8 хувийн баяжмал гарахаар байгаа гэж төслийн удирдлагын зүгээс мэдээлсэн. Гэтэл гаднын уурхайнууд 0.8-5 хувийн, тухайлбал, Австралийн Mount Weld орд 8 хувийн, АНУ-ын MP Materials орд 4-5 хувийн агуулгатай бөгөөд 20-30 хувийн баяжмал үйлдвэрлэдэг юм байна. Энэ нь тус төсөл ашигтай байж чадах эсэхэд эргэлзээ төрүүлж байна.

Хоёр.

Нэгэнт агуулга багатай орд газар учраас төслийг ашигтай болгохын тулд баяжмал, баяжмалаас цааш исэл гаргахаар төлөвлөжээ. Үүний тулд байгуулах гидрометаллургийн үйлдвэрт маш их хэмжээний буюу баяжмалын үйлдвэрт 15-20 МВт [мегаватт], исэл үйлдвэрлэвэл 20-30 МВт цахилгаан эрчим хүч шаардлагатай гэж мэдээлжээ. Энэ нь Ховд

аймгийн эрчим хүчний одоогийн хэрэглээтэй дүйж очих юм. Гэтэл одоогоор баруун бүсэд эрчим хүчний ийм том нэмэлт эх үүсвэр байхгүй бөгөөд Халзан бүрэгтэй төслийг Эрдэнэбүрэнгийн УЦС-аас хангахаар тооцоолсон. Тэгвэл БНХАУ-ын 266 сая долларын хөнгөлөлттэй зээлийг оролцуулан (нийт төсөвт өртөг нь бүр өндөр болно) барьж 2027 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн Эрдэнэбүрэнгийн УЦС-ын хүчин чадал 90 МВт бөгөөд үүний гуравны нэгээс тэн хагасыг Халзан бүрэгтэй төсөл хэрэглэх болж байна. Одоогоор боломжтой харагдаж магадгүй, гэхдээ сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжин хүн ам, барилга байшин нэмэгдэж, шинэ шинэ үйлдвэрлэл, усалгаатай тариалан бий болж, үүний улмаас жилдээ 8-12 хувиар өсөж байгаа баруун бүсийн эрчим хүчний хэрэглээг хангахад УЦС-ийн хүчин чадал хүрэлцэхгүй болох эрсдэлтэй гэж үзэж байна.

Гурав.

2023.01.11-нд Цөмийн энергийн комиссын ажлын албанаас Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд явуулсан “Тайлан хүргүүлэх тухай” 2023.01.11-ны 1/24 тоот албан бичигт Халзан бүрэгтэй ордыг ашиглах, ГХЭ-ийн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад дараах хүндрэлтэй асуудал үүсэж байна, технологийн хувьд дэлхийн хэмжээнд тогтсон, сайн туршлага нэвтрүүлэхээр сонголт харагдахгүй байна. Энэ нь ГХЭ-үүд ордод харьцангуй бага хэмжээтэй, химийн урвалуудад харилцан хөдөлгөөнтэй байдагтай холбоотой. Мөн ордыг ашиглахад гаргасан зардал, байгаль орчныг нөхөн сэргээх, хаягдлын менежментийг олон улсын болон үндэсний дүрэм, журам, стандартын дагуу хийхэд гарах зардалтай харьцуулсан сүүлийн үеийн судалгаа алга байна. Өмнө хийгдэж байсан судалгаагаар Халзан бүрэгтэй ордын хувьд хариуцлагатай уул уурхай явуулахад төвөгтэй, нөхөн сэргээх, хаягдлын менежмент хийх зардал өндөр учраас ордыг ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиггүй гэж үзсэн байна” гэж дурдсан байна.

Холбоо барих:  
Цахим шуудан: [urantsooj@gmail.com](mailto:urantsooj@gmail.com)  
Утас: 99192857